

**“АЧАА ТЭЭВРИЙН ДААТГАЛ”-ЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт
гэрээний нэр:

**“Ачаа, тээврийн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэх
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.
ИНЕГ/УЗ/ТББ/Б-37/20**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.08.14

Иргэний нисэхийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “***Ачаа, тээврийн даатгал***”-ын үйлчилгээ” –ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний техникийн шаардлага болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 8-р сарын 25-ны өдрийн 10.00 -цаг**-аас өмнө **Хан-Уул дүүрэг, 21-р хороо, Иргэнийн нисэхийн ерөнхий газар, 108 тоот өрөө, утас: 71-282116** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 8-р сарын 25-ны өдрийн 10.30 цаг**-т нээнэ.

***Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21-р хороо,
Иргэний нисэхийн ерөнхий газар, Худалдан авах ажиллагааны тасаг,
108 тоот өрөө, утас:71-282116***

БҮЛЭГ II. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ
ЗААВАРЧИЛГАА

А. Ерөнхий зүйл

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- Үүнд:
- **Татварын албаны цахим тодорхойлолт ирүүлэх**
 - **Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт ирүүлэх**
 - **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх**
 - **Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх**
- 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: **[Даатгалын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх.]**
- 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: **[Шуурхай дуудлагын тээврийн хэрэгслийн жагсаалтыг ирүүлэх,]**
2. **Тендерийн иж бүрдэл**
- Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
1. **Маягтын дагуу үнийн санал;**
 2. **Аж ахуйн нэгж байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх**
 3. **/2019 оны/ Аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх.**
 4. **2019 оны жилийн санхүүгийн тайланд хийгдсэн Санхүүгийн зохицуулах хорооны дүгнэлт, тайлангийн хариуг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.**
 5. **Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан төлбөрийн чадвар, дүрмийн сан, нөөцийн сангийн хэмжээг заасан тодорхойлолт ирүүлэх**
 6. **Дүрмийн сан нь 2 тэрбум төгрөгөөс багагүй байх**
 7. **Нөөц сан 1 тэрбум төгрөгөөс багагүй байх**
 8. **Нийт хөрөнгийн хэмжээ 5 тэрбум төгрөгөөс багагүй байна**
 9. **Хураамжийн орлого 1 тэрбум төгрөгөөс багагүй байна**
 10. **Сүүлийн 1 жилд /2019 он/ гүйцэтгэсэн даатгалын үйлчилгээний ижил төстэй туршлагын ирүүлэх гэдэгт: Ачаа /шатахуун/ тээврийн даатгалын**

үйлчилгээ үзүүлж байсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актыг гэрээ тус бүрээр ирүүлнэ.

11. Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон голлох боловсон хүчин нь даатгалын салбарт 3-с доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх.
12. Захиалагч тухайн тендерт оролцогчийн харилцагч банк болон Санхүүгийн зохицуулах хорооноос түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх.
13. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендер нь 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна
14. Техникийн шаардлагын дагуу даатгалын нөхөн төлбөрийн хувь, хэмжээний дагуу нийцлийн хүснэгт хийж ирүүлэх
15. Даатгалын гэрээний төсөл ирүүлэх

- | | |
|---|---|
| 3. Тендерийн үнэ | <p>3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.</p> <p>3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> |
| 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | <p>4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| 5. Алдааг залруулах | <p>5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <p>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</p> <p>(б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</p> |

- (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн шаардлага болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 1. Гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлэх**
- 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 2. Төслийн менежерийн шийдвэр**
- 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
- 3. Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр үйлчилгээ дууссан байх**
- 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
- 4. Аюулгүй байдал**
- 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.
- 4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
- 5. Зааварчилгаа**
- 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг

гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.

- 6. Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- 7. Үйл ажиллагааны хуваарь** 7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
- 7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
- 8. Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
- 9. Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үйл ажиллагааны хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үйл** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хуулийг баримтална.

**ажиллагаан
ы хуваарийг
өөрчлөх**

ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

**14. Үйлчилгээ
дуусгах**

14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.

15. Хүлээж авах

15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

**16. Эцсийн
тооцоо**

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Гэрээг
цуцлах**

17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- (а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
- (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг

² Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
(е) гүйцэтгэгч үйчилгээний гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**18. Гэрээг
цуцалсан
үед хийх
төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: **“Ачаа тээврийн даатгал” –ын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер. ИНЕГ/УЗ/ТББ/Б-37/20**
- 2.1 Үйлчилгээ нь: **“Ачаа тээврийн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэх** -с бүрдэнэ.
- 3.1 Төслийн менежер нь *ИНЕГ-н Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга С.Чинзориг*
- 4.1 Үйлчилгээ эхлэх өдөр [2020.11.07]
Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр [2021.11.07]
- 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [10] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,5%] байна.
Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10%] байна.

АЧАА ТЭЭВРИЙН ДААТГАЛЫН АЖЛЫН ДААЛГАВАР

Эрх зүйн шаардлага	Монгол улсын Даатгалын тухай хууль, Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага. MNS4978:2000	
Ачааны төрөл	Агаарын хөлгийн болон автомашины шатахуун, бүх төрлийн ачаа, бараа бүтээгдэхүүн, эд материал	
Ачааны тоо хэмжээ /ойролцоогоор/	1950тн	
Ачааны үнэ /ойролцоогоор/	4,7 тэрбум	
Ачаа хүргэх газар	Монгол улсын нутаг дэвсгэрт	
№	Даатгах эрсдлүүд	Хамгаалалт /хувь/
1	Замын хөдөлгөөнд оролцох үеийн осол аваар	100
2	Тээврийн хэрэгслийг байрлуулах үед учирсан осол аюул	100
3	Байгалийн гаралтай бүх эрсдэл	100
4	Дээрээс юм унах, цохигдох эрсдэл	100
5	Бүх төрлийн гал, тэсрэлт дэлбэрэлт, шаталт	100
6	Даатгуулагчийн буруутай үйлдлийн улмаас учирсан дээрх эрсдлүүд	100
7	Гуравдагч этгээдээс санаатай болон санаандгүй учруулсан хохирол / Тээврийн хэрэгсэл онхолдох, өөр хоорондоо эсвэл үл хөдлөх биет болон хөвөгч юмсыг мөргөх, цохих, гүүрийн нуралт, хулгай дээрэм, халдлага	100
8	Гарамтай газраар тээврийн хэрэгсэл усанд живэх, шидэгдэх, торх, чингэлэг, баглаа боодолд ус нэвтрэн орох	100
9	Гэрээнд заасан эрсдлийн улмаас ачаа бараа саатаж, тухайн ачаа барааны төрөл, шинж чанар, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалаад ачаа бараа хөлдөх, муудах, чанарын шаардлага хангахгүй болсон эрсдэл	100

Автомашины чиргүүл

№	Марк	Зориулалт	Улсын дугаар	Ашиглалтанд орсон он сар	Ачаа даац /кг/
1	ПЦ-86361	Шатахууны	5272 АЧ	2007.05	5,000
2	ПЦ-86361	Шатахууны	5274 АЧ	2007.05	5,000
3	ПЦ-86361	Шатахууны	5275 АЧ	2007.05	5,000
4	ПЦ-86361	Шатахууны	5276 АЧ	2007.05	5,000
5	КГБ-817	Ачааны	7460 АЧ	2007.05	5,000

Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл

№	Зориулалт	Марк	Улсын дугаар	Үйлдвэр лэсэн он	Ашиглалт ад орсон он сар	Ашигл агдсан жил	Үйлдвэр лэсэн улс	Арлын дугаар	Чиргу үлтэй эсэх	Ачаа даац /кг/
1	Шатах уун тээврийн автомашин	ЗИЛ АТЗ-433362	1356УБИ	2005	2007.05	10	ОХУ	3476402Х433362434	Тийм	5,000
2			1357УБИ	2005	2007.05	10	ОХУ	433362Х3454438	Тийм	5,000
3			1361УБИ	2005	2007.05	10	ОХУ	433362Х3448236	Тийм	5,000
4		ЗИЛ АТЗ-56451	1358УБИ	2005	2007.05	10	ОХУ	3436095	Тийм	5,000
5		Hyundai HD250	4779УНВ	2013	2013.08	4	Солонгос	KMFDA18CPDC075493	Үгүй	16,000
6		Hyundai HD250	4795УНЧ	2016	2016	1	Солонгос	KMFDA18CPHC094208	Үгүй	16,000
7		Hyundai HD250	4761УНД	2018	2018	1	Солонгос	KMFDA18CPKC101882	Үгүй	16,000
8	Шатах уун цэнэглэгч	Урал-375	3203УБХ	1983	1984.07	33	ОХУ	406291	Үгүй	5,500
9		ТЗА 7.5-5334	0963УБИ	1999	2007.06	10	ОХУ	47094	Үгүй	7,500
10	Ачааны	Kia K 2700 Bongo	8757 УНО	2019	2019.12	0,9	БНСУ	KNCSHY71CK7366419	Үгүй	1,000
11			1861 УНО	2019	2019.12	0,9	БНСУ	KNCSHY71CK7366420	Үгүй	1,000
12		Зил-45085	7813 УБУ	2004	2004.1	13	ОХУ	3478947	Үгүй	3,500
13		Зил-130	0631 УБК	1986	2003.09	14	ОХУ	2484591	Тийм	5,000

Зургаа. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [моо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____